



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 06 сарын 26-ны
өдрийн 2014 дугаарт бүртгэв.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар A/186

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хэмжил зүйн зөвлөлийн 2013 оны А/19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- Энэхүү журмыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлэхийг Хэмжил зүйн хүрээлэн /Д.Дамбасүрэн/, Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар /Л.Баярхүү/-т, хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, дотоод аудитын газар /Б.Ууганбаяр/-т тус тус үүрэг болгосугай.
- Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Стандарт, хэмжил зүйн газрын даргын
оны сарын нь өдрийн
дугаар тушаалтын хавсралт



ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллага (цаашид "хэмжил зүйн байгууллага" гэх) гүйцэтгэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад заавал хамруулах бөгөөд шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн байгууллага гүйцэтгэнэ.
- 1.3 Шалгалт баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгслийн тэмдэглэгээ, шошго нь дараах шаардлагыг хангасан байна.
 - хэмжих хэрэгслийн үйлдвэрлэгч, загвар, дугаар ба таних тэмдэг, хэмжил зүйн үзүүлэлтүүд;
 - импортоор нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын нэр эсвэл таних тэмдэг;
 - стандартад заасан холбогдох шаардлага;
 - хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдэг;
 - монгол, англи, орос аль нэг хэл дээр.

Хоёр. Шалгалт баталгаажуулалт хийх гэрээ

- 2.1 Хэмжил зүйн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагатай тухайн жилд хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулах гэрээг байгуулна.
- 2.2 Гэрээний загварыг Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага (цаашид "хэмжил зүйн төв байгууллага" гэх) батална.
- 2.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ, графикийг 3 (турав) хувь боловсруулж өмнөх оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох хэмжил зүйн байгууллагатай байгуулна.
- 2.4 Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээнд өөрчлөлт оруулах бол ажлын 20 хоногийн өмнө хэмжил зүйн байгууллагад өөрчлөлт оруулсан гэрээний төслийг албан бичгээр ирүүлнэ.
- 2.5 Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглалтад байгаа хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалт хоорондын хугацаанд ээлжит шалгалт баталгаажуулалтад заавал хамруулах үүрэг хулээнэ.
- 2.6 Гэрээнд шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн хэмжил зүйн үзүүлэлт, тоо ширхэг, ажил үйлчилгээний төлбөр, шалгалт баталгаажуулалт хийх газар, огноо холбогдох бусад зардлыг тодорхой тусгана.
- 2.7 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын гэрээний биелэлтийг талуудрын тохирууллагч агентлаг СТАНДАРТ, ХЭМЖИЙ ЗҮЙН ГАЗАР

Архивын эрхлэгч

2000 оны 08 сарын 04-ний өдөр
М.Жаргалант

**Гурав. Шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаа,
зохион байгуулалт**

- 3.1 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн төв байгууллагаас хэмжүүрийн улсын шалгагчийн эрх авсан ажилтан гүйцэтгэнэ.
- 3.2 Хэмжил зүйн төв байгууллагаас эрх авсан хэмжүүрийн улсын шалгагч нь Хэмжил зүйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтад заасны дагуу зөвхөн өөрийн харьяалагдах нутаг дэвсгэрт эсвэл холбогдох салбарын хүрээнд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.
- 3.3 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтад ашиглаж байгаа ажлын эталоныг улсын эталоноос, эсхүл гадаад орны хүлээн зөвшөөрсөн дээд шатны хэмжлийн эталонтой харьцуулан шалгалт тохируулгад хамруулсан байна.
- 3.4 Шалгалт баталгаажуулалтыг нэгж дамжуулалт бүхий ажлын этalon ашиглан хүчин төгөлдөр үндэсний стандарт, техникийн зохицуулалт, арга аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 3.5 Шалгалтад тэнцсэн хэмжих хэрэгсэлд хэмжил зүйн төв байгууллагаас олгосон шалгалт баталгаажуулалтын лацаар хэмжих хэрэгслийн эд анги, заалтыг өөрчлөх, тохируулах хэсгийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоходоо тухайн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг баримталаа.
- 3.6 Хэмжүүрийн улсын шалгагч шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоходоо тухайн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг баримталаа.
- 3.7 Шалгалт баталгаажуулалтаар стандартын шаардлага хангагүй, засварлах, ашиглах боломжгүй хэмжих хэрэгсэлд мэдэгдэл олгоно.
- 3.8 Шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн дугаар, загвар, хэмжил зүйн үзүүлэлтүүд болон хэрэглэгчийн нэр, хаяг зэргийг тусгасан протокол хөтөлнө.
- 3.9 Программ хангамж ашигладаг хэмжих хэрэгсэл нь MNS OIML D31 стандартын шаардлага хангасан байна. Тухайн хэмжих хэрэгслийг кодоор битүүмжлэх ажлыг хэмжүүрийн улсын шалгагч болон хэмжил зүйн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж түүний эрх бүхий ажилтан хийж нууцыг хадгална. Энэхүү үйл ажиллагааг гэрээгээр зохицуулна.
- 3.10 Хэмжил зүйн байгууллагын хүлээн авах нэгжээр хэмжих хэрэгслийг хүлээн авч, олгоходоо хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа, дагалдах хэрэгсэл, эд анги, бүрэн бүтэн байдлыг шалгаж бүртгэл хөтөлнө.
- 3.11 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг хүлээн авах нэгжээр дамжуулах, ашиглалтын байранд нь гүйцэтгэх тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хүсэлтээ гаргах бөгөөд тээвэрлэлт, шалгалт баталгаажуулалтын төлбөр болон холбогдох зардлыг бүрэн хариуцна.
- 3.12 Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд хэмжил зүйн байгууллагын ажлын эталоны хүчин чадал хүрэлцэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн хэмжих хэрэгслийг ашиглагч, эзэмшигчийн шалгалт тохируулгад хамрагдсан эталоныг ашиглана.
- 3.13 Хэмжил зүйн байгууллагаас хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг ашиглалтын байранд нь гүйцэтгэх тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах ажиллах нөхцөлөөр хангана.
 - гэрээнд заасан үүргийн дагуу хэмжүүрийн улсын шалгагч, этalon хэмжих хэрэгсэл болон туслах багаж хэрэгслийг шалгалт баталгаажуулалт хийх байранд хүргэх, буцах зардлыг бүрэн хариуцах;
 - шалгалт баталгаажуулалтыг хийхэд шаардагдах ажлын байр, туслах ажилтныг гаргаж өгөх;
 - ажлын эталоныг түр хадгалах өрөө гаргах, битүүмжлэн бүрэн бүтэн байдлыг хангах;
 - явуулын автомашин лаборатори ашиглах тохиолдолд зогсоол гаргаж, уг лабораторийг цахилгаан, дулаан, усан хангамжийн эх үүсвэрт холбох болонрын тохирууллагч агентлаг СТАНДАРТ, компанийн ГАЗАР

Архивийн эрхлэгч
Миргүйн
2020 оны 06 сарын 09-ийн одор

Дөрөв. Шалгалт баталгаажуулалтын төрөл


4.1 Анхдагч шалгалт баталгаажуулалт, түүний үр дүнг хүлээн зөвшөөрөх.

- 4.1.1 Хэмжих хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох чадавхаа үнэлүүлсэн, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр өмнө нь шалгалт баталгаажуулалтад хамрагдаж байгаагүй хэмжих хэрэгсэлд анхдагч баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.
- 4.1.2 Анхдагч шалгалт баталгаажуулалтыг энэ журмын 5.4-т заасны дагуу түүвэр баталгаажуулалт хийж болно.
- 4.1.3 Загварын туршилтад хамрагдаагүй, загварын гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, загварын баталгааны тэмдэгтүй хэмжих хэрэгслийг анхдагч шалгалт баталгаажуулалтад хамруулахгүй.
- 4.1.4 Аж ахуйн нэгж байгууллага нь импортоор нийлүүлэх, үйлдвэрлэх хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хүсэлтээ хэмжил зүйн төв байгууллагад хүргүүлнэ.
- 4.1.5 Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.1.6 Хэмжил зүйн төв байгууллага болон хүсэлт гаргагч аж ахуйн нэгжийн хооронд хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх гэрээ байгуулна. Гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллага чадавхаа үнэлүүлсэн байх;
 - хэмжих хэрэгсэл загварын туршилтад тэнцэж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн байх;
 - лаборатори нь олон улсын стандартын дагуу итгэмжлэгдсэн байх;
 - ажлын хэсгийн дүгнэлт гарсан байх.

- 4.1.7 Анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн гэрзэний хугацаа дуусмагц шалгалт баталгаажуулалтыг Хэмжил зүйн байгууллага гүйцэтгэнэ.
- 4.1.8 Аж ахуйн нэгж, байгууллага нь Хэмжил зүйн байгууллагаас баталсан анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээний загварын дагуу хэмжих хэрэгсэл тус бүрт гэрчилгээ олгох Хэмжих хэрэгслийн загвар, гэрчилгээний дугаар, серийн дугаарыг Хэмжил зүйн төв байгууллагад хагас жил тутам цахимаар хүргүүлнэ. Ирүүлсэн мэдээллийг Хэмжил зүйн төв байгууллага Хэмжил зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.2 Ээлжит болон давтан шалгалт баталгаажуулалт.

- 4.2.1 Ээлжит шалгалт баталгаажуулалтыг тогтоосон хугацаанд хэмжих хэрэгслийг баталгаажуулах үйл ажиллагаа бөгөөд баталгаажуулалт хоорондын хугацааг хэмжил зүйн төв байгууллага тогтооно.
- 4.2.2 Давтан шалгалт баталгаажуулалтыг баталгаажуулалтын хүчинтэй хугацаа дуусахаас өмнө хэрэглэгчийн хүснэгтээр гүйцэтгэнэ.
- 4.2.3 Давтан шалгалт баталгаажуулалтыг лац, тэмдэг нь хөндөгдсэн, арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн хэмжих хэрэгсэлд, эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг засварласны дараа гүйцэтгэнэ. ХУУЛБАР ҮНЭН
87
- 4.2.4 Хэмжил зүйн төв байгууллагад чадавхаа үнэлүүлж бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага хэмжих хэрэгслийг засварлах ажлыг гүйцэтгэнэ.



4.3 Магадлан тогтоох шалгалт баталгаажуулалт.

- 4.3.1 Магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтыг хууль, хяналтын байгууллагын хүсэлт, иргэд, аж ахуйн нэгжийн санал, гомдлын дагуу хэмжүүрийн улсын шалгач, улсын байцаагч нар хамтран гүйцэтгэж болно.
- 4.3.2 Шаардлагатай тохиолдолд анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгсэлд магадлан тогтоох шалгалтыг гүйцэтгэнэ.
- 4.3.3 Хэмжих хэрэгслийн магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтыг хүсэлт гарасан байгууллагын төлөөллийг байлцуулан гүйцэтгэж болно.
- 4.3.4 Магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтын тайлан, үр дүнг хүсэлт гарасан байгууллагад өгнө.

4.4 Түүвэр шалгалт баталгаажуулалт.

- 4.4.1 Түүвэр шалгалт баталгаажуулалтыг хэмжих хэрэгслийн нэг төрлийн багцаас 4.4.5-д заасны дагуу санамсаргүй байдлаар сонгосон, статистикийн хувьд тогтоосон тооны хэмжих хэрэгслээс дээж авч гүйцэтгэнэ.
- 4.4.2 Эзлжит буюу давтан шалгалт баталгаажуулалтын явцад түүвэр шалгалт баталгаажуулалт хийхгүй.
- 4.4.3 Түүвэр шалгалт баталгаажуулалт хийлгэх хүсэлтээс хэмжих хэрэгслийн тоо, хэмжих хэрэгслийн цуврал дугаарын хамт Хэмжил зүйн байгууллагад албан бичгээр ирүүлнэ.
- 4.4.4 Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хэмжих хэрэгслийн нэг төрлийн багцаас түүвэр шалгалт баталгаажуулалтын дээжийг 1-р хүснэгтэд заасны дагуу хэмжүүрийн улсын шалгач сонгоно.
- 4.4.5 Түүвэр шалгалт баталгаажуулалтыг 1201-ээс дээш тооны хэмжих хэрэгслийн нэг төрлийн багцад хийнэ.

1-р Хүснэгт. Хэмжих хэрэгсэлд түүвэр шалгалт баталгаажуулалт хийхэд дээж авах статистик

Нэг төрлийн багцад байх хэмжих хэрэгслийн тоо	Дээж авах үе шат	Дээжийн тоо		Тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо		Дээж авах хоёрдогч үе шат руу шилжих тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо
				Хүлээн зөвшөөрөх	Үл хүлээн зөвшөөрөх	
1201-3200	Анхдагч	80	80	2	5	3-4
	Хоёрдогч	80	160	6	7	-
3201-10000	Анхдагч	125	125	3	6	4-5
	Хоёрдогч	125	250	9	10	-
10001-дээш	Анхдагч	200	200	5	9	6-8
	Хоёрдогч	200	400	12	13	-

Тайлбар: Энэ хүснэгт нь ISO 2859-1 олон улсын стандартад нийцсэн болно.

4.4.6 Дээж авалт.

- 4.4.6.1 Түүвэрлэн сонгосон дээжид анхдагч шалгалтыг стандартын дагуу гүйцэтгэнэ. 87
- 4.4.6.2 Анхдагч дээж авалтын шалгалтад тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо хүлээн зөвшөөрөх тооноос хэтрээгүй бол нэг төрлийн багцад байгаа бүх хэмжих хэрэгслийг шалгалтад тэнцсэнд тооцон хэмжих хэрэгслээ бүрийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоно. Энэ тохиолдолд шалгалт хэмжил зүйн газар

Архивийн архивч
М.Жаргалан
2020 оны 06 сарын 04-ний одор

- баталгаажуулалтын төлбөрийг тухайн багцын бүх хэмжих хэрэгслийн тоогоор тооцно.
- 4.4.6.3 Анхдагч дээж авалтад тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо нь хүлээн зөвшөөрөх тооноос их байвал хоёрдогч дээж авалтыг хийнэ.
 - 4.4.6.4 Хоёрдогч дээжийг хүснэгтэд заасан тоогоор анхны багцаас түүвэрлэн улсын шалгагч сонгоно.
 - 4.4.6.5 Хоёрдогч дээж авалтад тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо нь хүлээн зөвшөөрөх тооноос хэтрээгүй бол нэг төрлийн багцад байгаа бүх хэмжих хэрэгслийг шалгалтад тэнцсэнд тооцон хэмжих хэрэгсэл бүрийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоно.
 - 4.4.6.6 Түүвэр шалгалт баталгаажуулалтаар анхдагч болон хоёрдогч дээжийн тэнцээгүй хэмжих хэрэгслийн нийлбэр тоо хүлээн зөвшөөрөх тооноос их байвал багцын бүх хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулна.
 - 4.4.6.7 Түүвэр шалгалт баталгаажуулалт хийхэд шалгалтад тэнцээгүй хэмжих хэрэгсэлд мэдэгдэл олгон тухайн аж ахуй нэгж, байгууллагад хүлээлгэн өгнө.

Тав. Хэмжих хэрэгслийн ашиглалтад хяналт тавих

- 5.1 Хэмжил зүйн байгууллага, хэмжүүрийн улсын шалгагч болон аж ахуйн нэгж, байгууллагын хэмжил зүйн ажилтан хэмжих хэрэгслийн ашиглалтад хяналт тавина.
- 5.2 Хэмжих хэрэгслийг шалгалаа баталгаажуулалтад хамруулсны дараа баталгааны лац, тэмдэг хөндөгдсөн, гэрчилгээний хүчинтэй хугацаа, хэмжил зүйн үзүүлэлт нь холбогдох стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд ашиглалтын хяналтыг тавина.

Зургаа. Шалгалаа баталгаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих

- 6.1 Энэ журмын хэрэгжилтэд хэмжил зүйн төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан хэмжих хэрэгслийн шалгалаа баталгаажуулалтад хяналт тавина.

Долоо. Хүлээлгэх хариуцлага

Бүртгэлийн дугаар

87

- 7.1 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

-- 0 --

